

## ЭРДЭНЭ РЕСУРС 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАНГ ТОЛИЛУУЛЖ, БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН ШИНЭ МЭДЭЭЛЛИЙГ ТАНИЛЦУУЛЛАА

### Хэвлэлийн мэдээ

Халифакс хот, Нова Скошиа муж  
2020.03.17

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD; MSE:ERDN) ("Эрдэнэ Ресурс" эсвэл "Компани") 2019 оны 12 сарын 31-ээр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Баян Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлтийн мэдээллээс гадна COVID-19 вирустэй холбоотой нөлөөллийн тухай мэдээлэл хүргэж байна. Компанийн SEDAR-т бүртгэгдсэн 2019 оны санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан ("MD&A" буюу "Удирдлагын хэлэлцүүлэх ба дүн шинжилгээ") нь энэхүү хэвлэлийн мэдээний салшгүй нэг хэсэг болно.

### Тодруулга:

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли танилцуулахдаа: "Өнгөрсөн жил бид газрын дөт гүнд өндөр агуулга бүхий Хөндий Алтны Төслийн эцсийн ТЭЗҮ ("BFS")-г боловсруулах ажлыг түргэвчлэхээр төсөл хөгжүүлэлт, хайгуулын олон ажил гүйцэтгэлээ. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд бид хоёр ордын анхан шатны эдийн засгийн тооцоолол ("АШЭЗТ" буюу "PEA") болон Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ ("PFS")-г боловсруулан танилцуулж, 3.7 г/т дундаж алтны агуулга бүхий 400,000 унц илээр олборлох боломжтой үйлдвэрлэлийн нөөцийг тодорхойлж, хоёр ашиглалтын тусгай зөвшөөрөл авч, усны нөөцийг бүртгүүлэн, газар ашиглалтын зөвшөөрөл авсан ба хайгуулын хөтөлбөрөөр ордын нөөцийг нэмэгдүүлсэн амжилттай байлаа."

"Бид Монгол улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих, хувьцаа эзэмшигчдэдээ өгөөжийг нэмэгдүүлэх, бүх оролцогч талуудад үнэ цэн бий болгох хэтийн зорилгынхоо төлөө Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк ("ЕСБХБ" буюу "EBRD")-ны дэмжлэгтэйгээр тууштай ажилласаар байх болно. Дээрх зорилтын хүрээнд эцсийн ТЭЗҮ-ийг 2020 оны дундуур танилцуулах ба 2020 онд төслийн санхүүжилт, бүтээн байгуулалт эхлэхэд шаардлагатай бүх тусгай зөвшөөрлүүдийг авснаар 2021 онд алт үйлдвэрлэл эхлүүлэх төлөвлөгөөтэй байна."

### 2019 оны онцлох үйл явдлууд:

### Хөндий Алтны Төсөлд COVID-19 хэрхэн нөлөөлж болзошгүй тухай

Компани 2020 оны 1-р сарын сүүлээс эхлэн COVID-19 вирусний тархалтаас оролцогч талуудыг хамгаалах арга хэмжээний хүрээнд томилолтын хязгаарлалт хийж, зайнаас ажиллах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийн дэмжлэгийг Монголын болон олон улсын ажилтнууддаа үзүүлснээр бүх оролцогч талууд, үндсэн үйл ажиллагаагаа вирусний тархалтын эрсдэлээс хамгаалсаар байна. Хэдийгээр манай эцсийн ТЭЗҮ-ийн судалгаа төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа ч бид үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан зарим нэг ажил хойшлох, хүндрэл үүсэх магадлалтай байгааг ойлгож, эрсдэлд өртөж болзошгүй үйл ажиллагааг хянаж байгаа. COVID-19 вирустэй холбоотой хүндрэл, өөрчлөлт гарах тохиолдолд мэдээлэл хүргэх болно.

## Хөндий Алтны Төсөл – 100% Эрдэнэ Ресурсийн эзэмшил

- > Tetra Tech Inc-ийн боловсруулсан NI 43-101 Техникийн Тайлангийн эерэг үр дүнг танилцуулсан бөгөөд энэхүү тайланд Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ, Алтан Нарын шинэчилсэн АШЭЗТ багтсан (нэг унц алтны үнийг \$1,300 ам.доллар байхаар тооцсон):
  - > Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ-д татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалтаар тооцоход) (“NPV5%”) \$97 сая ам.доллар болон дотоод өгөөжийн түвшин (“IRR”) 42% хэмээн тооцоологдов.
  - > Өнөөгийн алтны үнэд (нэг унц алтны үнийг \$1,500 ам.доллар) тулгуурлан тооцоолбол татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалтаар) (“NPV5%”) \$144 сая ам.доллар ба дотоод өгөөжийн түвшин (“IRR”) 58% хэмээн тооцоологдоно.
  - > Алтан Нарын шинэчилсэн АШЭЗТ-д татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалтаар) (“NPV5%”) болон дотоод өгөөжийн түвшин (“IRR”) нь тус бүр \$24 сая ам.доллар болон 92%-аар тайлагнасан бөгөөд Баян Хөндий төслийн дэд бүтцийг ашиглан, үйлдвэрлэлийн хоёрдугаар үе шат болгон хөгжүүлэхээр тусгасан.
  - > Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ-д танилцуулснаар ашиглалтын хугацаанд татвар болон элэгдлийн өмнөх ашиг нийтдээ \$211 сая ам.доллар байна.
  - > Уурхай ашиглалтын хугацааны хүдрийн дундаж агуулга нь Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ-д 3.73 г/т, Алтан Нарын АШЭЗТ-д 3.46 г/т байхаар төлөвлөсөн.
  - > Баян Хөндийд 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 520,700 унц баттай болон бодит геологийн нөөц (“Measured and Indicated Resources”) тооцоологдсон нь 2018 оны 9-р сард тайлагнасан нөөцийн тайлангаас 20% өссөн үзүүлэлт юм.
  - > Баян Хөндийд 3.7 г/т дундаж алтны агуулга бүхий 422,000 унц батлагдсан ба магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserves”)-ийг тооцоолов.
  - > Уурхайн ашиглалтын хугацаа 11 жил, үүнд: бүтээн байгуулалтад 1 жил, Баян Хөндий ордын ашиглалтын хугацаа 6 жил, Алтан Нар ордын ашиглалтын хугацаа 3 жил байхаас гадна уурхайн хаалтын хугацааг 1 жил байхаар төлөвлөсөн.
  - > Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ-д тодорхойлсноор жилд үйлдвэрлэх алтны дундаж хэмжээ 61,000 унц бол Алтан нарын АШЭЗТ-д тодорхойлсноор жилд үйлдвэрлэх алтны дундаж хэмжээ 45,300 унц, мөнгөний дундаж хэмжээ 205,000 унц байна.
  - > Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ-д нэг унц алт үйлдвэрлэх нийт нэгжийн өртөг (“AISC”) нь \$746 ам.доллар, Алтан нарын шинэчилсэн АШЭЗТ-д нэг унц алттай дүйцэх нэгж буюу AuEq-ийн (“AuEq”-ын тухай тэмдэглэлтэй 2019 оны 10 сарын 21-ний хэвлэлийн мэдээнээс танилцана уу) нийт нэгжийн өртөг нь \$931 ам.доллар байхаар тусгасан.
  - > Баян Хөндийн анхны хөрөнгө оруулалт 40 сая ам.доллар болон Алтан Нарын нэмэлт хөрөнгө оруулалт 2 сая ам.доллар байхаар тооцоолсон.
  - > Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ-д тодорхойлогдсон эргэн төлөгдөх хугацаа: 2 жил
  - > Монгол улсад оруулах өгөөж өндөр, уурхайн ашиглалтын хугацаанд Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татвар (ААНОАТ), Ашигт Малтмалын Нөөц Ашигласны Төлбөр (АМНАТ) ба бусад татвар, хураамжид 82 сая ам.доллар төлж, Баянхонгор аймагт 300 гаруй шинэ ажлын байр бий болгоно.
- > 2019 оны эцэст тусгай зөвшөөрөл, төслийн санхүүжилт болон бүтээн байгуулалтын ТҮЗ-ийн зөвшөөрөл авахад шаардлагатай Баян Хөндийн эцсийн ТЭЗҮ (“BFS”), анхны инженерчлэл загвар (“FEED”)-ын ажлуудыг эхлүүлсэн.
  - > Судалгаануудыг Монголд үйл ажиллагаа эрхэлж байсан туршлагатай болон төслийн тоног төхөөрөмж, санхүүжилтэд хамтран ажиллах боломжтой Ази тивд төсөл хөгжүүлж байсан туршлагатай байгууллагуудын нэгдэл хамтран боловсруулж байна. 2020 оны хагаст танилцуулах энэхүү судалгаанд уурхайн загварчлалын судалгаа, боловсруулах үйлдвэрийн анхны инженерчлэл загвар, холбогдох дэд

бүтэц, гидрогеологийн судалгаа, хаягдлын удирдлагын нарийвчилсан төлөвлөгөө болон шинэчилсэн эдийн засгийн загварчлал багтана.

- > 2019 оны 8-р сарын 5-нд Баян Хөндийн, 2020 оны 3-р сарын 5-нд Алтан Нарын ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг тус тус хүлээн авлаа.
  - > Ашиглалтын тусгай зөвшөөрлүүд нь 30 жилийн хугацаатай бөгөөд ирээдүйд 70 хүртэл жилээр сунгах боломжтой тул Хөндий Алтны Дүүргийн судалгааг урт хугацаанд үргэлжлүүлэх боломж олгож байна.
- > Баян Хөндийн усны нөөцийг тооцоолж, гидрогеологийн өрөмдлөгийг гүйцэтгэсэн:
  - > 2019 онд Баян Хөндийн боловсруулах үйлдвэрийн төлөвлөж буй байршлаас 3.2 км-ийн зайд таван (5) ус үйлдвэрлэлийн цооногийг өрөмдөж тодорхойлсон.
  - > Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам нь Баян Хөндийн ашиглалтын хугацааны төлөвлөж буй боловсруулах үйлдвэрийн шаардлагыг хангахад шаардлагатай усны нөөцийг батлан, бүртгэсэн.
  - > Түүнээс гадна, төлөвлөж буй хээрийн ангиас 200 метрийн зайд усны худаг гарган батлуулж, бүртгүүлсэн.
- > Баян Хөндийн эцсийн ТЭЗҮ-ийн геотехникийн өрөмдлөгийн хөтөлбөрийг 2019 оны 4-р улиралд гүйцэтгэв:
  - > Баян Хөндийн ил уурхайн төлөвлөлтийн хүрээнд төрөл бүрийн литологийн бат бэх, тогтвортой байдлын үнэлгээг гаргах зорилгоор 2019 оны 4-р улиралд зургаан (6) геотехникийн цооног (745 метр) өрөмдсөн.
  - > Судалгааны үр дүн нь эцсийн ТЭЗҮ-д багтах ба урьдчилсан ТЭЗҮ-д геотехникийн мэдээлэл уламжлалт налууугаар тооцогдсон. Энэ үр дүн нь ил уурхайн ханын налуугийн тогтвортой байдлыг тодорхойлно.
- > Баян Хөндийн хүдэрт металлургийн нэмэлт судалгаа хийж гүйцэтгэсэн:
  - > Канад улсын Бритиш Колумбад төвтэй Blue Coast Research нь нунтаглах процессыг оновчлол; алт авалтын хувьд оновчтой нунтаглах хэмжээг тодорхойлох; ус ашиглалтыг багасгах зорилгоор хамгийн үр дүнтэй ус шавхах процедурыг тодорхойлох; алт авалтын хүрээнд нүүрсэнд уусах чанарыг тодорхойлох; боловсруулах үйлдвэрийн лагийн хатуулгын хувийг тодорхойлох; хаягдал дахь цианидын хэмжээг бууруулж хоргүйжүүлэлтийн туршилтыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай судалгаа, туршилтуудыг хийж гүйцэтгэв.
  - > Өнөөдрийг хүртэл хийсэн судалгаануудын үр дүн нь Баян Хөндий ордын алт авалт нь өндөр байгааг баталж, төлөвлөж буй боловсруулах үйлдвэрийн бохирдол, хаягдлыг зохицуулах гол төсөөллүүдийг тодорхойлсон.
- > Эцсийн ТЭЗҮ-д орох зардлын тооцооллын хүрээнд худалдан авалтын дараах ажлуудыг эхлүүлсэн:
  - > Боловсруулах үйлдвэр, тоног төхөөрөмжийн багц үнийн саналын хүсэлтийг боловсруулж, урьдчилсан шалгаруулалтад хамрагдсан ханган нийлүүлэгчид болон гүйцэтгэгчдэд хоёр долоо хоногийн хугацаанд хүргүүлэхээр төлөвлөж байна.
  - > 2-р улиралд хариуг хүлээж авахаар төлөвлөж байна.
- > Төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (“ESIA”)–г Sustainability East Asia компани боловсруулж байна:
  - > Судалгаагаар орон нутгийн иргэд, ажилтнуудын нөхцөл байдал, бүс нутгийн цаг агаар, агаарын чанар, усны нөөц, замын хөдөлгөөн болон эдийн засагт үзүүлэх нөлөөллийг судалж, үнэлсэн.
  - > Төслийн цар хүрээ бага, салбартаа тэргүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ авдаг, төслийн эдийн засгийн үр өгөөж нь байгаль орчны бага, дунд зэргийн нөлөөллөөс харьцангуй өндөр байх хүлээлттэй байна.
  - > ТУЗ болон санхүүжүүлэгчийн баталснаар Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг 2020 оны эхний хагаст олон нийтэд танилцуулна.

- > Баян Хөндий төслийн Монголын Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (“DEIA”) нь Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (“ESIA”) -д тулгуурласан бөгөөд 2020 оны эхний хагаст олон нийтийн хэлэлцүүлгийг хийснээр эцэслэгдэнэ.
- > Барилга байгууламжтай холбоотой зарим голлох тусгай зөвшөөрөл, зохицуулалтын зөвшөөрлийг авсан.
  - > Ашигт Малтмал, Газрын Тосны Газар (“АМГТГ”) нь Баян Хөндийн Техник Эдийн Засгийн Үнэлгээг (“Mongolian Feasibility Study”) баталсан.
  - > Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь Хөндий Алтны Төслийн боловсруулах үйлдвэр, дэд бүтцэд ашиглахаар төлөвлөсөн усны нөөц, ундаргын хэмжээг баталсан.
  - > Баян Хөндий ил уурхай болон холбогдох гадаргуун дэд бүтцэд шаардлагатай 100 га талбайн зөвшөөрлийг газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу орон нутаг баталсан.

## Хайгуул

- > 2019 онд Баян Хөндий, Алтан Нар төслүүд дээр нийт 4,367 тууш метрийн 22 өрмийн цооног өрөмдөн, Алтан Нар төслийн талбайд өнөөг хүртэл танилцуулсан хамгийн өндөр үр дүн\* бүхий хайгуулын хөтөлбөрийг хэрэгжүүллээ:
  - > Баян Хөндий – Мидфийлд бүс: Урьдчилсан ТЭЗҮ-ийн нөөцийг батлах өрөмдлөгөөр 45 г/т алтны агуулгатай 8 метрийн интервал агуулсан 5.9 г/т алтны агуулга бүхий 112 метрийн интервал огтлогдсон. Түүнд 81 г/т, 95 г/т болон 129 г/т алтны агуулгатай сорьцууд тогтоогдсон (BKD-261)
  - > Баян Хөндий - Страйкер болон Мидфийлд бүс: Нарийвчилсан өрөмдлөгөөр BKD-269 цооногт 2.4 г/т алтны агуулга бүхий 32 метр интервал, BKD-270 цооногт 1.7 г/т алтны агуулга бүхий 37 метр интервалууд тус тус огтолж, Баян Хөндий ордод эрдэсжилт үргэлжилж байгааг тодорхойлов.
  - > Өмнөд Баян Хөндийн үргэлжлэл: Баян Хөндий ордоос өмнө зүгт 350 метрт өрөмдлөг хийсэн бөгөөд 2.4 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал (BKD-268) огтолсон нь Баян Хөндийн алтны ордтой ижил төрлийн галт уулын нэгдлийн хувиралд агуулагдсан алтны эрдэсжилт байв.
  - > Алтан Нар – Нээлтийн бүс: Gap Zone (“Урьд нь өрөмдлөг хийж байгаагүй талбай”) дахь өрөмдлөгөөр 17 г/т алтны агуулга бүхий 23 метрийн интервал огтолсон бөгөөд үүний 7 метрийн интервал нь 70 метрийн босоо гүнд 45.7 г/т алт, 93.4 г/т мөнгө, 1.54% хар тугалга, 3.4% цайрын агуулгатай байв (TND-135).
  - > Алтан Нар – Нээлтийн бүс: 12.2 г/т алтны агуулга бүхий 10 метрийн интервал огтолсон ба үүний 2 метр нь 52.9 г/т алтны агуулгатай байсан (TND-134) нь “Gap Zone” -ийн өмнө бүсэд өндөр агуулга бүхий эрдэсжилт байгааг баталж, 4.68 г/т алтны агуулга бүхий 10 метрийн интервал (TND-138) огтолсноор Нээлтийн бүсийг урд зүгт 10 метр тэлэв.
  - > Хар Морь алтны нээлт: Баян Хөндий ордоос хойд зүгт 3.5 км-т Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд илрүүлсэн шинэ талбай бөгөөд 87.8 г/т алтны агуулга бүхий чулуун дээж гадаргаас илэрсэн.  
\*\*Интервалууд нь хэмжигдсэн зузаан болно. Жинхэнэ зузааны талаар тус бүрийн хэвлэлийн мэдээнээс танилцана уу.

## Компанийн тухай

- > 2019 онд хөрвөх нөхцөлтэй зээл болон үнэт цаасны санхүүжилтээр \$11.9 сая кан.долларын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлж, Баян Хөндий Алтны Төслийн урьдчилсан ТЭЗҮ, эцсийн ТЭЗҮ, Сэндсторм БЦАТ буцаан худалдан авалт, хайгуулын хөтөлбөр болон эргэлтийн хөрөнгөд зарцуулсан.
  - > 2019 оны 11 сард Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (“EBRD”) -ны оролцоотой \$5 сая ам.доллар (\$6.6 сая кан.доллар) -ын санхүүжилтийг эцэслэв.
  - > Үнэт цаас хаалттай хүрээнд нэмж гаргах замаар нийт \$5.3 сая кан.долларын хөрөнгө оруулалт татан төвлөрүүлсэн.

- > Өнөөгийн \$3.8 сая кан.долларын эргэлтийн хөрөнгө нь Компанийг эцсийн ТЭЗҮ боловсруулж дуусах хүртэл санхүүжүүлэд хүрэлцэнэ.
- > 2019.04.12-нд Сэндсторм Гоулд Лимитед (“Sandstorm Gold Limited”) компаниас борлуулалтын цэвэр ашгийн төлбөр (“БЦАТ” буюу “NSR royalty”)-ийн 50%-ийг эргүүлэн худалдаж авсан:
  - > Энэхүү борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийн бодит үнэ цэн нь эргүүлэн худалдан авахад төлсөн \$1.2 сая кан.доллараас илүү гэж үзэж байна.
- > 2019 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцэст Компанийн алдагдал \$2,683,292 байсан нь 2018 оны 12 сарын 31-ны \$3,656,990 кан.долларын алдагдалтай харьцуулахад буурсан үзүүлэлт юм:
  - > 2019 онд капиталжуулсан зардлыг хамруулсан хайгуулын зардал \$6,694,914 байсан нь өнгөрсөн оны \$5,958,692-той харьцуулахад өссөн үзүүлэлт. Энэ нь Хөндий Алтны төслийн АШЭЗТ, Баян Хөндий урьдчилсан ТЭЗҮ ба Алтан Нар төслийн шинэчилсэн АШЭЗТ-той холбоотой техникийн зөвлөхийн зардал нэмэгдсэнтэй холбоотой.
  - > Компанийн захиргаа, удирдлагын зардал (мөнгөн бус, хувьцаанд суурилсан нөхөн төлбөр болон элэгдлийг оролцуулахгүй) нь 2019 онд \$1,142,956 байсан нь 2018 оны \$1,407,536-тэй харьцуулахад буурсан үзүүлэлт юм. Энэ нь боловсон хүчний өөрчлөлт болон маркетингийн зардал буурсантай холбоотой.

### Хөндий Алтны Төсөлд нөлөөлөх магадлалтай COVID-19-ийн нөлөөлөл

Компани 2020 оны 1-р сарын сүүлээс эхлэн COVID-19 вирусний тархалтаас оролцогч талуудыг хамгаалах арга хэмжээний хүрээнд томилолтын хязгаарлалт хийж, зайнаас ажиллах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийн дэмжлэгийг Монголын болон олон улсын ажилтнууддаа үзүүлснээр бүх оролцогч талууд, үндсэн үйл ажиллагаагаа вирусний тархалтын эрсдэлээс хамгаалсаар байна. Саяхнаас Канад улсын ба мужийн засаг захиргааны зөвлөмжийн дагуу Канадын оффисын ажилтнуудын хүрээнд дээрхтэй ижил хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж эхэллээ. Нэгдүгээр сараас эхлэн Монгол улсын засгийн газар орон нутаг, хот хоорондын болон олон улсад зорчих иргэд болон бараа таваарын хөдөлгөөнийг хязгаарласнаар иргэдээ вирусээс хамгаалах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Хэдийгээр COVID-19 вирусний тархалт нь манай үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөхийг урьтаж таамаглах боломжгүй ч одоогоор 2020 оны дундуур танилцуулах эцсийн ТЭЗҮ нь төлөвлөгөөний дагуу боловсруулагдаж байна. Мөн хөл хорионоос үүдэн зарим нэг төлөвлөгөөт ажлууд удааширч байгаа ч тусгай зөвшөөрөл болон хайгуулын ажлууд үргэлжилсээр байна. Компани үүссэн нөхцөл байдлаас эрсдэлд өртөж болзошгүй хэмээн доорх үйл ажиллагаанд онцгойлон анхаарч байна:

- > Эцсийн ТЭЗҮ: Эцсийн ТЭЗҮ-ийн хээрийн болон лабораторийн судалгаануудын ихэнх нь 2019 оны сүүл, 2020 оны эхээр дууссан бөгөөд одоогоор ихэвчлэн мэдээлэл боловсруулах ажлууд үлдээд байна. Түүнээс гадна COVID-19-ээс үүдсэн худалдан авалттай холбоотой БНХАУ-Монгол улсын хоорондох хязгаарлалтууд аажмаар цуцлагдаж байна. Зарим саатал, хүндрэлүүд гарч байгаа хэдий ч эцсийн ТЭЗҮ-ийн үр дүнг 2020 оны дундуур танилцуулах төлөвлөгөөнд өөрчлөлт орохгүй ба үр дүнг танилцуулснаас хойш 45 хоногийн дотор тайланг бүртгүүлнэ.
- > Тусгай зөвшөөрлүүд: Манай Улаанбаатарын баг саяхан Алтан Нарын ашиглалтын тусгай зөвшөөрлийг авснаар тусгай зөвшөөрлүүдтэй холбоотой ажил амжилттай өрнөж байна. COVID-19-ийн хүрээнд олон нийтийн цугларалт, уулзалтуудын тодорхой хязгаарлалттай байгаа нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлуулах зарим ажлыг хойшлуулж байгаа ч харьяалах төрийн удирдлагын дээд байгууллагуудтай ойлголцолд хүрэн ажиллаж байна. Ирэх саруудад нэмэлт хязгаарлалт тавихгүй, хориг цуцлагдвал тусгай зөвшөөрлийн ажлууд үргэлжлэн төлөвлөгөөний дагуу хэрэгжинэ.

- > Хайгуул ба хээрийн үйл ажиллагаа: 2020 оны 1-р сард танилцуулсан хайгуулын ажлын үр дүнд суурилан геологийн мэдээлэл боловсруулж төлөвлөгөө гаргах ажиллагаа хийгдсээр байна. Аливаа томилолтын хязгаарлалт гараагүй тохиолдолд 2-р улиралд Хар Морь төслийн хүрээнд зураглал, геохими, геофизикийн хээрийн судалгаанууд хийгдэхээр төлөвлөж байна. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой хээрийн үйл ажиллагааны хувьд холбогдох судалгаанууд энэ долоо хоногт эхэлнэ.
- > Хөрвөх чадвар ба Санхүүжилт: 2019 оны 11 сард Эрдэнэ Ресурс нь Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкнаас 5 сая ам.долларын хөрвөх нөхцөлтэй зээлийн санхүүжилт авсан нь эцсийн ТЭЗҮ-ийг боловсруулж дуустал төлөвлөсөн зардлуудыг санхүүжүүлэх боломжтой. Компани нь 2020 онд багтаан төслийн санхүүжилт татан төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа ч өнөөгийн зах зээлийн тодорхойгүй нөхцөл байдлаас үүдэн саатах эрсдэлтэй байгаа тул зардал хэмнэлт, болзошгүй нөхцөл байдалд бэлдэх, голлох хөрөнгүүдээ хамгаалах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхэллээ.

### Хөндий Алтны Төслийн тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

2019 оны 10 сард Эрдэнэ Ресурс нь хөндий Алтны Төслийн техникийн тайланг (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) танилцуулсан бөгөөд нэхүү техникийн тайланд Баян Хөндий ордын (“Bayan Khundii”) урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл (“урьдчилсан ТЭЗҮ”, “PFS”) болон Алтан Нар ордын (“Altan Nar”) шинэчилсэн анхан шатны эдийн засгийн тооцоолол (“АШЭЗТ”) орсон болно. Урьдчилсан ТЭЗҮ-д Баян Хөндий, Алтан Нар ордын татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (“NPV5%”) (алтны үнийг \$1,300 ам.доллар/унц байхаар төсөөлсөн) тус бүр \$97 сая ам.доллар, \$24 сая ам.доллараар тооцоологдсон. Баян Хөндий ба Алтан Нарын дотоод өгөөжийн түвшин (“IRR”) нь тус бүр 90%, 42% гэж тооцоолсон. Урьдчилсан ТЭЗҮ-д 0-7 жилд Баян Хөндий ордыг ашиглах ба 3.73 г/т дундаж агуулга бүхий хүдрийг боловсруулж, жилд 61,000 унц алтыг илээр олборлох, 7-10 жилд Алтан Нар ордыг ашиглан, 3.46 г/т дундаж агуулга бүхий хүдрийг боловсруулж, жилд 48,000 унц алтыг олборлохоор төлөвлөж байна. Баян Хөндий ордод уламжлалт нүүрсэнд уусгах боловсруулах үйлдвэрийг байгуулахаар төлөвлөсөн. 2019 оны 8-р сард Баян Хөндий ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан бөгөөд компани 2021 оноос эхлэн олборлолтыг эхлүүлэхээр төлөвлөж байна.

Анхан шатны эдийн засгийн тооцоолол нь урьдчилсан таамаглал бөгөөд зарим тооцоололд боломжит нөөц агуулсан. Боломжит нөөц нь урьдчилсан болон эцсийн техник, эдийн засгийн тооцоололд нөөц хэмээн багтаахад геологи, эдийн засгийн хувьд эрсдэл ихтэй. Эдийн засгийн үр ашиг багатай геологийн нөөцийг үйлдвэрийн нөөц, эдийн засгийн тооцоололд багтаахгүй.

### Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)–ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмет спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан

тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screenmetallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 г дээжний 75 микроноос бага байх 30 г бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцагт үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн хийж Улаанбаатар дахь Эс Жи Эс ("SGS") лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнийн ложистикийн гэрээт компани Монруд ХХК гүйцэтгэдэг.

### Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 3 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com)-оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээллийг авахыг зөвлөж байна.

### Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.**

### Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCiL5s59j3SLmya9vo2-KXoA>